

## ***Л.Ариун***

### **Дата сэтгүүл зүй**

Дата сэтгүүл зүй бол урьдчилан сэргийлэх чухал хэрэгсэл. Дата буюу тоо баримтын анализ хийснээр асуудал үүсч, маш их хор хохирол учруулахаас өмнө тухайн асуудлыг таньж мэдэх боломжтой. Тэрхүү асуудлыг магад сэтгүүл зүйн өөр арга хэрэгслээр олж таних боломжгүй ч байж болно шүү дээ. Сүүлийн үеийн жишээ татахад, 1999 онд Америкийн түүхэн дэх санхүүгийн хамгийн том пирамидын дуулианыг илчилсэн байдаг. Бернард Мэдофын бий болгосон энэхүү сүлжээг дуулиан үүсэхээс нэлээд хэдэн жилийн өмнө дата аналит Харри Маркополос задлан шинжилж, Мэдофын амлаж байсан санхүүгийн ашиг нь хууль эрх зүйн хувьд ч, математикийн хувьд ч огт боломжгүй зүйл гэдгийг Аюулгүй байдлын газар болон Санхүүгийн хороонд мэдэгдэж байжээ. Энэхүү дүгнэлтийг хийхийн тулд Маркополос нэлээд өргөн хүрээний мэдээллийн задлан шинжилгээг хийсэн. Уул шугамандаа энэ бол сэтгүүлчдийн хийх ёстой ажил байсан юм.

Гэхдээ энэ бол маш бэрх ажил юм.

Хүснэгтлэн тооцоолох, цуулбарлах, графикаар дүрслэх гэх зэрэг дата сэтгүүл зүйн янз бүрийн хэрэгсэл нь энэ ажлыг маш их хөнгөвчилдөг. Юун түүрүүнд, дата сэтгүүл зүй нь судалгааны ажлыг байнга, тасралтгүй хийх аргад сургана. Цуулбарлах буюу цахим хуудаснаас тодорхой мэдээллийг олох нь янз бүрийн байгууллагуудын шинээр гаргаж тавьж буй мэдээллийг түүвэрлэх замаар тэд өдөр тутам хэрхэн ажиллаж буйг ажиглах боломж олгодог. Нөгөө талаар, дата сэтгүүл зүй нь их хэмжээний мэдээлэл дээр ажиллах боломжийг олгодог бөгөөд энэ нь маш чухал. Ялангуяа орчин үед төрийн байгууллагууд мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулийн дагуу их хэжээний мэдээллийг сэтгүүлчдэд нээлттэй болгож байна. Хязгааргүй их мэдээллийг толгойдоо гашилгах, эсвэл тооцоолон бодох ур чадвартаа найдах нь мэдээж хэцүү. Иймээс мэдээллийг задлан шинжлэх компьютерийн програм бидэнд байна.

Сэтгүүл зүй бол үргэлж л мэдээллийн задлан шинжилгээ байсан. Уол Стрийт Журнал (The Wall Street Journal) 1889 онд хөрөнгийн биржийн талаарх Дау Жонс (Dow Jones)-ын үдээс хойш гардаг сонингоор эхэлсэн. Спортын сэтгүүл зүйд ч дата амин чухал байр суурийг эзэлсээр ирсэн. Жон Сноу 19 дүгээр зуунд Лондонд дэгдсэн холер өвчний газрын зургийг гаргаснаар энэ өвчний талаарх ойлголт эрс өөрчлөгдсөн. Тэрээр сэтгүүлчдэд ажлын шинэ загварыг бий болгож өгсөн.

Гэхдээ бидний мэдэх дата сэтгүүл зүй бол “компьютерийн тусламжтай эрэн сурвалжлах сэтгүүл зүй” (CAR) хэмээн нэрлэсэн судалгааны арга барилаас эхтэй. Аль 50-аад онд сэтгүүлчид нийгмийн шинжлэх ухаанд ашигладаг компьютерийн программуудын тусламжтайгаар баримт мэдээллийг задлан шинжилж эхэлсэн байдаг. Анхны бүтээлүүдийн нэг нь 1952 онд Америкийн CBS телевизээр нэвтэрсэн түүхтэй. Тухайн үед Америкийн ерөнхийлөгчийн сонгуулийн дүнд анализ хийхийн тулд UNIVAC 1 компьютерийг ашиглаж байжээ.

Эхэндээ ихэд хөөрч догдолж байжээ. Сэтгүүлчид бүтээлдээ ямар компьютер ашиглаж, хичнээн баримтад анализ хийснээ гайхуулдаг байлаа. Энэ нь орчин үеийн хэлээр бол, “Би iPhone 5-аар таван ярилцлага хийсний үр дүнд ийм дүгнэлтэд хүрлээ” хэмээн онгирохтой адил юм. (инээв). Тухайн үед CAR-ын мэргэжилтнүүд тоо баримт олж авах үйл явцад хэт их анхаарал хандуулж, түүний цаана ямар асуудал нуугдаж, ямар бодит түүх байна вэ гэдгийг орхигдуулах хандлагатай байв. Өөрөөр хэлбэл уншигчдад “Хар даа, бид нар ийм их мэдээллийг задлан шинжилж чадна” хэмээн гайхуулахаас хэтэрдэггүй байсан юм.

Цахимжих үйл явц тасралтгүй үргэлжилсээр 1980-аад онд мэдээллийн сан ашиглах нь сэтгүүл зүйн үйл ажиллагааны маш чухал хэсэг болж ирсэн. Хэвлэл мэдээллийн байгууллагуудад тоо баримтыг график дүрсээр харуулах үүрэг зорилготой шинэ ажлын байр ч бий болж эхлэв. Ямартаа ч өнөөдөр дата сэтгүүл зүй нь дэлхийн хэвлэл мэдээллийн хөгжлийн хамгийн чухал чиг хандлагуудын нэг нь болоод байна.

Мэдээж хэрэг дата сэтгүүл зүй хийхийн тулд

- сэтгүүл зүй
- програмчлал
- веб дизайны гэсэн гурвалсан ур чадварыг тодорхой хэмжээгээр ашиглах шаардлагатай.

Зарим үед эдгээрийг нэг хүн гүйцэтгэдэг, эсвэл ийм чадвартай хүмүүсээр баг бүрдүүлж ажиллаж болно. Гол нь энэ гурван талбарын онцлогийг багийн гишүүд бүгд мэддэг байх ёстой, тэгж байж л тэд үр бүтээлтэй хамтран ажиллаж, харилцан ойлголцоно. Жишээлбэл та кодлох ажлын талаар ямар ч ойлголтгүй бол танд кодлогчтой хамтран ажиллах нь бэрхшээлтэй байх болно. Учир нь үүргээ гүйцэтгэхийн тулд тэр хүнд юу шаардлагатай байх вэ гэдгийг та мэдэхгүй. Тиймээс та дээрх гурван төрлийн ур чадварыг бүрэн эзэмших албагүй ч, тодорхой мэдлэгтэй байх ёстойгоос гадна дор хаяж аль нэгийг нь төгс чаддаг байх ёстой.

Статистикийн суурь мэдлэгтэй, нийгмийн шинжлэх ухааны бусад арга зүйн талаар ойлголттой байх ёстой. Тоо баримтыг ашиглахдаа маш хянамгай ажиллаж,

нотлогдохооргүй дүгнэлт гаргаж нийтэд зарлахаас зайлсхийх хэрэгтэй. Тийм ч учраас дата сэтгүүл зүйг нотолгоонд суурилсан сэтгүүл зүй хэмээн нэрлэдэг. Дата гэдэг нь нэг чухал үндсэн шинж чанарыг агуулдаг. Тэр бол баримт.

Тухайн асуудал, үйл явдлыг хэдий чинээ сайн судалж, баримтжуулна, төдийчинээ л бодит байдалд ойртоно. Тиймээс дата сэтгүүл зүй бол үзэл бодолд бус, баримтад л илүү ойр байдаг. Асуудлыг дэвшүүлж, болсон явдлыг харуулахын тулд тоо баримт олж авах нь зөвхөн эхний алхам. Гэхдээ дата мэдээллийг нягтлан судлах ажлыг хэн нэгэн судлаачид даалгах бус, сэтгүүлч хүн өөрөө хийх нь маш чухал. Харамсалтай нь маш олон сэтгүүлч тоо баримтыг өөрөө ухахын оронд тэдгээр тоог мэддэг хүнээс ярилцлага авчихдаг. Гэтэл:

- Тэдгээр мэргэжилтэн нь сонирхлын зөрчилтэй байж болно.
- Тэд дүгнэлт хийхдээ хувийн үзэл бодлоо хавчуулсан байж болно.
- Өөрийн хийсэн ажлыг зөвтгөхийн тулд ямар нэг зүйлийг хачирлаж ч магад.

Сэтгүүлч хүн хэрхэх ёстой вэ гэвэл, эхлээд тоо баримтыг өөрөө судалж, асуудлыг мэдэж аваад, дараа нь холбогдох эх сурвалжаас ярилцлага авах ёстой.

Ташрамд дурдахад, би “датад суурилсан сэтгүүл зүй” гэдэг нэр томъёонд дургүй. Учир нь энд дата л хамгийн чухал зүйл юм шиг сонсогдоод байгаа юм. Сэтгүүл зүйн ач холбогдлыг хэт багасгах хандлага харагдаад байна л даа. Энэ тухай би ярилцлагынхаа эхэнд дурдсан. Үйл явцын хамгийн чухал нь тоног төхөрөөмж, техник биш. Тэд бол зүгээр л туслах хэрэгсэл. Хамгийн чухал нь сэтгүүлчид, тэдний шүүмжлэлт сэтгэлгээ юм.

Ажлын шинэ арга хэрэгсэл цаг үргэлж л гарч ирж байсан. Тэдгээр нь аргачлалыг л өөрчилж ирсэн болохоос биш, сэтгүүл зүйг өөрийг нь өөрчилж байсангүй. Мэдээллийн ихэнхийг цахим хэлбэрээр ашиглах боломж гарч ирж байгаа учир сэтгүүлчид тэдгээрийг цуглуулж, шинжлэн дүгнэж чадах л ёстой. Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахтай нэгэн адил. Дата сэтгүүл зүй бол хүнтэй ярилцлага хийхийн оронд тоо баримттай ярилцлага хийж, мэдээлэл олж авдаг гэхэд болно.

*Тиймээ, бид өөрчлөлтийн цаг үед амьдарч байна, эдгээр өөрчлөлт нь цахимжих чиг хандлагатай маш ихээр холбоотой. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын, ялангуяа сонин хэвлэлийн бизнес тийм ч сайнгүй байна. Мэдээллийн олон компани бизнесийн загвараа өөрчилж, шинэчлэх шаардлагатай нүүр тулаад байгаа боловч үүнд хойрго хандсаар байгаа. Тэд интернэтийг алга болчихоосой гэж хүлээж буй мэт байгаа боловч ийм зүйл болохгүй нь тодорхой шүү дээ.*

Одоогоор бидэнд юу харагдаж байна вэ гэвэл, институц буюу байгууллагад суурилсан сэтгүүл зүй нийгэмд тулгуурлах шилжилтийг хийж байна. Мэдээлэл, харилцааны шинэ суваг, санхүүжилтийн шинэ арга хэрэгсэл, хил хязгаарыг дамнан

хамтран ажиллах боломж нээгдэж буйтай холбоотойгоор сэтгүүлчдийн хараат бус байдал урьд урьдынхаас илүү сайжирч байна. Хуучинсаг хэвлэл мэдээллийн аль нэг байгууллагад ажиллах гэж зовж байгаа сэтгүүлчид өөрчлөлтийг санаачлах, эсвэл зүгээр л яваад өгөх боломжтой болж байна.

*Хэрэв та сайн сэтгүүлч бол хүмүүс таны ажил олгогч байгууллагыг бус, харин таныг дагах илүү сонирхолтой байх болно.*

Заримдаа шинэ цахим хуудсанд хэрэглэгчийн сонирхлыг татах нь аль нэг хуучин мэдээллийн хэрэгслийг сурталчлахаас илүү амархан байдаг. Яг л ийм үед дата сэтгүүл зүйн өөр нэгэн чухал талыг харагдана. Энэ нь хэлэх гэсэн зүйлээ шинэлэг байдлаар бусдад хүргэх боломж юм.

Мэдээллийг нэг газар, нэг байгууллагаас олон хүнд түгээх хуучны загвар үеэ өнгөрөөж байна. Орчин үед хүмүүс олон хүнд мэдээлэл түгээх нь хэвийн үзэгдэл болоод байгаа. Үүнээс гадна бүтээл хэвлэгдсэн цаг мөчид сэтгүүл зүйн үүрэг дуусгавар болохгүй. Дараагийн алхам бол хүнд хүргэх явдал. Үр дүнд хүрэхийн тулд зорилтот бүлгийнхээ сонирхол, хэрэгцээг сайн мэдэх хэрэгтэй. Хэрэв та бүтээлээ үр дүнтэйгээр хүргэж чадахгүй л бол архивт зориулж бичсэн болж таарна.

- Хүрээлэл үүсгэх
- нөлөө бүхий гол хүмүүс буюу гол тоглогчдыг олж тогтоох
- Бичих ур чадвараа харуулах
- Мэдээллийн хэрэгслийн анхаарлыг татаж чадах нь хэвлэл мэдээллийн шинэ орчинд шаардагдаж буй чухал ур чадвар юм.

Дата сэтгүүл зүй бол эдгээрийн иж бүрдэл мөн. Нийгмийн мэдээллийн сүлжээ болон бусад хэрэгслийг мэргэжлийн сэтгүүл зүйн түвшинд ашиглах ур чадвар.

Нийгмийн мэдээллийн сүлжээг нийгмийн харилцааг судлах хэрэгсэл болгон ашиглаж болох бөгөөд энэ нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйд маш чухал арга юм. Facebook болон LinkedIn дэх сүлжээ, хүрээллийг судалж гаргасан эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээлийн жишээ цөөнгүй бий. Словакийн нэгэн эмэгтэй өөрийн орны эрүүл мэндийн салбарын худалдан авалттай холбоотой авлигын хэргийг илрүүлэхийн тулд эмнэлгийн удирдлага, худалдан авалтыг гүйцэтгэдэг компаниудын хүрээлэл, найзын сүлжээг судалж, амжилтад хүрсэн байдаг. Нийгмийн мэдээллийн сүлжээнд хүмүүс өөрийнхөө тухай маш их мэдээллийг үлдээдэг учир тэднийг хэрхэн судлах аргаа мэддэг байх хэрэгтэй.

Судалгааны арга хэрэгсэл болгож ашиглахаас гадна анхаарах өөр зүйл бас бий. Нийгмийн мэдээллийн сүлжээ бол таны мэдээллийг түгээх, уншигчидтай харьцах, үр дүнд хүрэх чухал хэрэгсэл мөн. Хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ тал дээр хэрхэн ажилладагийг харахад заримдаа хөгжилтэй байдаг.

*Жишээлбэл тэд хэлэлцүүлэгт оролцож, хэрэглэгчидтэй хутгалдахгүй. Тэд нэвтрүүлэг, бүтээл буюу бүтээгдэхүүнээ гаргаад л болчихдог. Энэ бол маш буруу юм. Нийгмийн мэдээллийн сүлжээг үдэшлэг мэтээр бодоод үз. Та ямар нэгэн баяр, цэнгүүнд оролцохоор ирлээ гэж бодъё. Хүмүүс тантай яриад байхад хариулахгүй байвал бүдүүлэг гэж бодно. Үдшийн турш та үе үе өрөөний гол дунд очиж зогсоод хэлэх гэсэн зүйлээ чангаар хэлээд, хүмүүс тантай ярилцах гэж ойртох бүрт “би ямар ч хэлэлцүүлэгт оролцохгүй” хэмээн хариулаад байх юм бол таныг галзуу, эсвэл хэт биеэ тоосон амьтан гэж л дүгнэнэ.*

Хэвлэл мэдээллийн уламжлалт байгууллагууд иймэрхүү сэхүүн, солиотой араншинг ихээхэн гаргадаг. Гэвч харилцааны энэ загвар үеэ өнгөрөөж байна. Уншигч, үзэгчтэйгээ хэрхэн харьцахаа мэдэхгүй байвал удахгүй тэднийг алдах болно.

Миний бодлоор Guardian сайн ажиллаж байгаа, мөн New York Times, Los Angeles Times- ыг дурьдаж болох юм. Норвегийн хэвлэл өөрчлөлтөд маш сайн зохицож байгаа. Данийн өргөн нэвтрүүлгийн корпораци мэдээллийн санд шинжилгээ хийх тусгайлсан албатай болсон гэх мэт санаанд шууд орж ирж байгаа цөөн хэдэн жишээ. Дата сэтгүүл зүйн шилдэг бүтээлийг эрэлхийлж байгаа бол олон улсын хэмжээний төсөл, хамтын ажиллагааны үр дүнг орхиж болохгүй.

*Жишээлбэл Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн олон улсын консорциум (ICIJ) байна. Тэд татвараас зайлсхийх зорилготойгоор нээсэн офшор данс, компаниудын талаар мэдээлэл олж аваад, олон оронд хамтын ажиллагааны баг үүсгээж ажилласан. Тэдний судалгааны ажил хагас жил орчим үргэлжилсэн бөгөөд илүү үр дүнд хүрэхийн тулд гурав удаа давалгаалах маягаар бүтээлүүдээ дэлхий дахинаа цацсан аж.*

Германы томоохон банкуудын ерөнхий захирал, Хятад, Английн хамгийн том баячууд зэрэг алдар нэртэй олон хүнийг тэд илчилсэн юм. Энэ төсөл өнгөрсөн жил маш их дуулиан тарьсан. Тэр ч хэмжээгээрээ нэр хүнд бүхий олон шагнал хүртсэн. Тэдний бүтээл гарсны дараа Европын холбооноос мөнгө угаах явдлыг зогсооход чиглэсэн хууль журмыг шинэчилж эхэлсэн.

Энэ бүгдийг Дата сэтгүүл зүйн арга хэрэгсэлгүйгээр бүтээх боломжгүй юм.

Мөн олон улсын сэтгүүлчдийн хамтын ажиллагаа маш чухал байсан. Хамарсан орон болгонд өндөр түвшний мэргэжлийн үйл ажиллагаа шаардагдаж байсан учир энэ төсөл дээр олон улсын баг ажиллахаас өөр замгүй байсан. Өнөөдөр үнэгүй аппликэйшн, нийгмийн мэдээллийн сүлжээний тусламжтайгаар бүх зүйл боломжтой болж байна. Дата сэтгүүл зүй бол орчин үеийн сэтргүүл зүйн залуу үймүүлэгч юм.

Дэлхийн сэтгүүл зүй өнөөдөр интернетийн хурдацтай хөгжил, технологийн дэвшлийн нөлөөгөөр өмнөх түүхэндээ байгаагүй их хэмжээний мэдээлэлтэй харьцах болсон. Тиймээс мэдээллийг зураг, өнгө, график, дүрсээр дүрслэн харуулах шинэ чиг хандлага бүхий Дата сэтгүүлзүй дэлхийн сэтгүүл зүйд нэвтрээд байна. Гэхдээ Дата мэдээллийг сэтгүүлч хакердаж юм уу, хууль бусаар олж авахыг хориглодог. Харин Дата сэтгүүл зүй сэтгүүлчдэд цаг зав гаргаж, өгөгдлүүд болон мэдээллийн санг судлаж, тэндээс олсон баримт мэдээллийн мөрөөр бататгаж, бусад эх сурвалжуудтай уулзаж, мэдээгээ хүргэх юм байна. Гэхдээ гол зарчим үнэн бодитой мэдээлэл байх ёстой. Дата сэтгүүл зүйг сэтгүүлчид хэрэглэснээр Засгийн газар болон бусад яамд, газрууд, тухайн хувь хүнд зөв шийдвэр гаргахад ихээхэн нөлөө үзүүлдэг гэнэ. Жишээ нь, Америк төвтэй Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчид Дата сэтгүүл зүйг ашиглан УИХ-ын гишүүн С.Баярцогтын гадаадад байгаа дансыг илрүүлж мэдээлсэн гэж байна. Мөн Япон Улсын Засгийн газрын нуун дарагдуулж байсан мэдээллийг Дата сэтгүүл зүйг ашиглан олж авч байжээ. Гэтэл Хятад Улсад ард иргэд нь агаарын бохирдлыг хэмжиж, судлаад сэтгүүлчдээр дамжуулан Засгийн газартаа мэдээллээ хүргэсэн байна. Харин Английн “Sun” сонины сэтгүүлчид эмнэлгийн 2,9 сая гаруй төлбөрийн тооцоонд дүн шинжилгээ хийжээ. Ингэхэд 3600 гаруй тохиолдол нь урьдчилан сэргийлэх боломжтой өвчин, халдварт өвчин, мэс заслын алдаатай тохиолдлууд илэрсэн гэнэ. Нэг ёсондоо эмчийн хариуцлагагүй байдлаас нас барахгүй байсан олон хүн нас барсныг тогтоосон юм байна. Сэтгүүлчид энэ мэдээллийг гаргаж ирэхийн тулд олон нийтийн хүсэлтийн бүртгэлийг мэдээллийн сангаас судлаж, өвчтний ар гэр бүл, нас барсан хүмүүсийн ар гэр бүлийн хүмүүстэй уулзаж, тогтоожээ. Энэ мэт тодорхой жишээнүүд Дата сэтгүүл зүйд эрэн сурвалжлах сэтгүүл зүй багтдаг гэдгийг харуулж байна. Гэхдээ сэтгүүлчид Дата мэдээллийг цуглуулахдаа IT-ийн мэдлэг, чадварыг эзэмших юм уу, эсвэл IT-ийн мэргэжилтэнтэй хамтрах хэрэгтэй гэж байна. Дата сэтгүүл зүйгээр бичье гэвэл сэтгүүлчийн өмнө мэдээллийн маш өргөн сүлжээнээс хайлт хийж баримт, мэдээлэл олохоос эхлээд сонин сэтгүүл, google.com болон бусад вэб сайтуудаас сонголт хийн, маш их унших, телевизийн

сувгуудыг үзэх гэх шаардлага тавигддаг. “Нью Йорк times” сонин Дата сэтгүүл зүйг нэлээд чадварлаг ашигладаг гэнэ. Дата сэтгүүл зүй нь сэтгүүл зүйн хөгжил дэвшлийг хурдасгаж, сэтгүүлчийн чадвар, мэдрэмж, чанар чансааг ахиулах нь дамжиггүй гэж мэргэжлийн туршлагатай сэтгүүлч, шинжээч, судаачид үздэг байна. Уг сургалтанд оролцсон сэтгүүлчид “Бид энэ сургалтаас сэтгүүл зүйн шинэ чиг хандлага ямар байгаа талаар шинэ мэдээллээр толгойгоо цэнэглэлээ. Цаашид сэтгүүлчийн ур чадвараа дээшлүүлж, уран бүтээлээ улам сайжруулан баяжуулах олон сайхан санаа олж авлаа” хэмээн олзуурхан ярьж байсан.